



ЧУЛУУНХОРООТ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА Д.НАРАНБААТАР ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.07.19 № 517

танай 2024.06.15-ны № 06 -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Чулуунхороот сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Чулуунхороот сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

011021448

Дүгнэлт

Чулуунхороот сумын Монгол ардын намын Чулуунхороот сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Чулуунхороот сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр 1 хуудас хавсаргав.

Хувийг: "Чулуунхороот сумын Монгол ардын намын хороо"-нд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛИЙН ТУХАЙХУУЛИЙН 37 ДУГААР ЗҮЙЛИЙН 37.5 -Д ЗААСАН
ДҮГНЭЛТ ГАРАХТАЙ ХОЛБОГДУУЛАН ЧУЛУУНХОРООТ СУМААС АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ
ОРУУЛАХ САНАЛЫН ЖАГСААЛТ**

1. Сумын Баруун баг буюу Галуут багт малчдын отор нүүдэл хийх боломжийг бий болгон улз голд гүүрэн байгууламж барих /модон/
2. Хүн амын нягтаршил нэмэгдэж байгаатай холбогдуулан төмөр замын хэсэгт шинээр цэцэрлэг барьж ашиглалтанд оруулах
3. Албан хаагчдын орон сууц хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
4. Үүлдэрлэг мал аж ахуй эрхлэх боломжийг бүрдүүлэн малчин өрхийн сургийн бүтцийг сайжруулах малжуулах төслийг хэрэгжүүлэх
5. Багшийн хөгжлийн дэмжих хөтөлбөртэй уялдуулан сурагчийн хөгжлийг хангах зорилгоор сургуулийн орчинг цахим болгох
6. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг үр дүнтэй болгож жил бүр төсвийн дэмжлэг үзүүлэх "Тэр бум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод үржүүлэг, хүнсний ногоо тариалах иж бүрэн цогцолбор байгуулах
7. Худаг уст цэгийн тоог нэмэгдүүлэх, тэжээл тарих үйл ажиллагааг дэмжин ажиллах
8. Сумын төвийн зүүн хэсэг /гааль, хилийн цэргийн салбар, төмөр зам/-ийн айл өрхүүдийн цахилгаан эрчим хүч тасалдах явдлыг зогсоох зорилгоор дотоод шугам сүлжээг засварлах, тог хуваарилах байгууламж барих
9. Чулуунхороот сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах
10. Орон нутгийн иргэд, хүүхэд багачуудын хүсэл сонирхолд нийцсэн биеийн тамир спортын цогцолбор байгуулах /дугуйн зам, хөл бөмбөг, тоглоомын талбай г.м/

ДАРГА



Д.НАРАНБААТАР

